



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 656

Улаанбаатар хот

┌ Автомашины тоо төрөл тогтоох тухай ┐

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам тээврийн салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Зам тээврийн хөгжлийн яамны үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4.Арга хэмжээний биелэлтийн хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006909
34-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
 656 дугаар тогтоолын хавсралт



**ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД
 АШИГЛАГДАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ**

№	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /Жип/	2
2		Хот доторх ажлын суудлын автомашин	2
3		Хот доторх ажлын жижиг оврын автобус /Микро автобус/	1
Нийт автомашин			5